

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас тус тус баталсан холбогдох журмууд болон “Сүү” ХК-ийн Дүрмийг тус тус удирдлага болгон явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:10,

Хурлын байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын байранд,

Хурлын дарга: Ц.Соёл-Эрдэнэ,

Хурлын нарийн бичгийн дарга: Б.Цэрэндорж,

Хурлын ирц: Саналын эрх бүхий 320,290,018 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 93.1%,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
4. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Танилцуулсан нь:

Нарийн бичгийн дарга:

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Сүү” ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна.

Та бүхэнд ээлжит хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

“Сүү” ХК-ийн саналын эрх бүхий нийт 344,000,000 ширхэг хувьцааны 93.1% болох нийт 320,290,018 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн байгаа бөгөөд Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн байх тул хурлын ирц бүрдсэн байна.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 03-р сарын 15-ны өдрийн № 03 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын дагуу батлагдсан хуралдааны дэгийг танилцуулъя.

Хуралдааны дэгийг танилцуулав.

Хурлыг нээж ХЭХурлын дарга, “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ц.Соёл-Эрдэнэ үг хэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Эрхэмсэг хатагтай, ноёд оо, хүндэт хувьцаа эзэмшигчид ээ, та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлэхийн ялдамд “Сүү” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирж, өнгөрөгч оны санхүү, үйл ажиллагааны тайланд дүгнэлт хийн, хэлэлцэх асуудлуудад өөрийн үнэтэй саналаа дэвшүүлэх гэж буй та бүхэндээ талархлаа илэрхийлье.

Сүү хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагын баг, нийт ажилтнууд 2018 онд тодорхойлсон стратеги төлөвлөгөө, мөн ойрын болон дунд хугацааны зорилтуудаа маш амжилттай биелүүлж, хувьцаа эзэмшигчдийнхээ үр өгөөжийг нэмэгдүүлэхээр шаргуу ажилласныг энд онцлон дурдмаар байна.

Энэ удаагийн хурлаар бид Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж, батлах болно:

- ✓ Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх,
- ✓ ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох,
- ✓ Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэж баталхаас гадна, ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх болно.

Ингээд “Сүү” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг албан ёсоор мэдэгдэж байна.

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн үнэтэй санал, хүсэлтээ байнга илгээн, “Сүү” ХК-ийнхаа үйл ажиллагааг үргэлж дэмжин ажиллахыг хүсье.

Нарийн бичгийн дарга:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргад баярлалаа. Одоо дэгийн дагуу хэлэлцэх эхний асуудал болох Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Гүйцэтгэх захирал М.Мандхай танилцуулах байгаа. Танилцуулга хийсний дараагаар та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуух зүйлс байвал асууж болно.

- “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Мандхай Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн талаар танилцуулга хийв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Нармандах: Санал хэлэх гэсэн юм. Сүү, сүүн бүтээгдэхүүний тоонд гүүний айраг заавал орох байх. Адууны сүүг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар ойрын ирээдүйд бодож төлөвлөж байгаа юу? Энэ бол том боломж Монголчуудад байгаа гэж бодож байна. Үүнийгээ ашиглаж чаддаггүй шүү.

Хариулт:

Гүйцэтгэх захирал М.Мандхай: Асуулт болон санал гэж хүлээж авлаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Хандсүрэн: Манайх Сүү ХК-ийнхаа сүүг 7 хоног бүр хэрэглэдэг. Бусад сүүг бодвол 2-3 хоноод гашилдаг. Энэ бол сайн тал. Үүнээс гадна хүүхдэд, сахарын өвчтэй хүнд зориулсан бүтээгдэхүүн хийж болох уу гэж асууя?

Хариулт:

Гүйцэтгэх захирал М.Мандхай: Баярлалаа. Олон улсын түвшинд фермүүд чанараа баталгаажуулж өгдөг жишиг байдаг. ХАА салбарт дан ганц үйлдвэрлэгч түүхий сүүний чанарыг сайжруулах гэвэл амжилтад хүрэхгүй. Тэгэхээр улсын түвшинд, бодлогоор малчид фермерүүдтэй түүхий сүүний чанарыг сайжруулах тал дээр хамтарч ажиллах ёстой юм. Сүү ХК-ийн хувьд шүдний өвчлөлттэй тэмцэх зэрэг эрүүл мэндийн асуудлуудтай холбоотойгоор олон ажил төлөвлөөд явж байна. Бид Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкнаас 50,000 еврогийн буцалтгүй тусламж хүлээн авч, бэлтгэн нийлүүлэгчидрүү чиглэсэн, ялангуяа эмэгтэй бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхжуулах сургалтууд хийхээр зорьж ажиллаж байна.

Бидний ирээдүйн зорилго бол малчдыг фермжүүлэхэд чиглэж байгаа. Бид цаашид олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорьж байгаа боловч ХАА-н сүүний чанарыг сайжруулахгүй бол энэ зорилго маань хэрэгжихэд хүндрэлтэй байгаа. Үүн дээр бид анхаарч ажиллана. Мөн бусад сегментүүд болох хүүхэд болон залуучуудад зориулсан хялбар савлагаатай шинэ бүтээгдэхүүнүүд гаргахаар бэлтгэл ажил хангагдаж байна. Туршилтууд хийгдэж байгаа. Иймээс цаашид бүтээгдэхүүний нэр төрөл улам нэмэгдэнэ.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Нямдаваа: Компани өгөөжтэй сайн ажилласан байна. Гүйцэтгэх удирдлага шинэчлэгдсэн байна та өөрийгөө товч танилцуулаач?

Хариулт:

Гүйцэтгэх захирал М.Мандхай: Би Англи улсад бизнесийн удирдлагын чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан. 2008 онд Англи улсаас ирээд Монгол улсын эдийн засагт түлхэц болж байгаа буюу хөгжиж буй 3 том салбарт ажилласан. Оюу толгой компанид төслийн менежментийн чиглэлээр, томоохон төслүүдийг удирдаж ажиллаж байсан. Мөн үл хөдлөх хөрөнгийн салбарт ажилласан туршлагатай.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Нямдаваа: EBRD-гаас 12 сая долларын зээл авсан гэсэн. Үйл ажиллагаанд нөлөөлөхүйц шаардлага тавьсан уу? Давхар бүртгүүлнэ гэсэн яриа сонсогдсон. Хаана бүртгүүлэх вэ?

Хариулт:

Гүйцэтгэх захирал М.Мандхай: EBRD маш өндөр шалгуур тавьдаг. Аль ч компани тавигдах шалгуурт нь тэнцэх амаргүй. Санхүүгийн хувьд сахилга баттай учираас Сүү хувьцаат компанид итгэж зээл олгосон. Шалгуур нь компанийг өсөхөд хязгаар тавиагүй, нэмэлт хувьцаа гаргах, давхар бүртгэл хийлгэх зэрэгт нээлттэй байгаа. Бид ирэх 5 жилд бүтээгдэхүүнээ экспортод гаргах зорилгынхоо хүрээнд магадгүй нэмэлт хувьцаа гаргах юм уу, дахин бонд босгох, давхар бүртгэлээр гадаадын хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгох зэрэг хэд хэдэн хувилбаруудыг ярьж байгаа. Албан ёсоор шийдвэр гаргаагүй байна. EBRD энэ тал дээр манайхыг нээлттэй орхисон учраас боломж бидэнд бий.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал "Сүү" ХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг СЗХ-ны 2011.12.07-ны өдрийн №367 тоот тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэн сонгох тухай асуудал байгаа.

Та бүхэнд өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа буюу бүрэн эрх нь дуусгавар болж байгаа ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. Ш.Батжаргал

Хараат бус гишүүнээр:

1. Н.Цэрэндорж
2. Ш.Даваалимбэ
3. Г.Баяр
4. П.Мэндсайхан

Та бүхэнд "Сүү" ХК-ийн ТУЗ-д нэр дэвшиж буй гишүүдийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. С.Сүхболд

Хараат бус гишүүнээр:

5. Н.Цэрэндорж
6. Ш.Даваалимбэ
7. Г.Баяр
8. П.Мэндсайхан

ТУЗ-д нэр дэвшиж буй гишүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дэлгэцээр танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

Нарийн бичгийн дарга: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал байгаа. Та бүхэнд “Сүү” ХК-ийн дүрэм оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулъя. Үүнд:

1. “Сүү” ХК-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт: “...Англиар: “Milk” Joint stock Company...” гэж заасан хэсгийг “...Англиар: “Suu” Joint stock Company...” гэж өөрчлөн найруулах,

2. “Сүү” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт: “Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно” гэж заасан хэсгийг “Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө нэмэгдэж, хорогдоно” гэж өөрчлөн найруулах,

3. “Сүү” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт: “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасан хэсгийг “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно” гэж өөрчлөн найруулах,

4. “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.20 дахь хэсэгт: “ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй” гэж заасныг компанийн дүрмээс хасах,

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх ёстой байгаа. Та бүхэнд “Сүү” ХК-ийн 2017 оны ногдол ашиг тараалтын тайланг танилцуулъя.

"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн №02 тоот Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолоор компанийн нийт хуримтлагдсан ашгийн дүнгээс 2017 онд нэгж хувьцаанд 3 төгрөг буюу нийт 1,032,000,000 /Нэг тэрбум гучин хоёр сая/ төгрөгийг ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд энэхүү шийдвэрийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хувьцаа эзэмшигчдэд нийт 1,032,000,000 төгрөгийн ногдол ашгийг тарааж дуусгасан болно. Анхаарах хандуулсанд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Төрболд: Олон улсын банкуудаас зээл авчихаар ногдол ашиг тарааж болох уу? Нэмэлт бонд гаргаж болох уу? Компанийн зүгээс хүсэлтүүдээ гаргаад явж байгаа гэж ойлгох уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал М.Мандхай: Хязгаарлалтууд бол байгаа. Цэвэр ашгийн 30 хүртэл хувиар ногдол ашиг тараах боломжтой гэсэн нөхцөл тавьсан. Дэлхийн томоохон санхүүгийн аудитын компаниар аудит хийлгэж байгаа. Одоогоор Хонгконгд техникийн хэсгүүд нь шалгагдаж байна. Ирэх 5-р сард аудитлагдсан тайлангаа гарахаар энэ асуудал тодорхой болно гэж бодож байна.

Нарийн бичгийн дарга: Одоо дэгийн дагуу хурал завсарлана. Завсарлагааны дараа тооллогын комисс тогтоол танилцуулна.

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудасны загварыг танилцуулж, бөглөх зааварчилгааг дахин өгөөд хурал завсарлав.

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн
2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
№03 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХК-ийн "ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
/Хэлэлцэх асуудал №1/

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Холцдэй Инн" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал		

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Та санал авах хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт "✓" зовоол + тэмдэглэлээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чаддаггүй тохиолдолд өөрийн хариуцаж, Тэтгэвэр комиссын /ЦЭК/ дээр оролцож хуралтай төмөрч, санал авах хуудсаар саналаа өгнө.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотариатаар гарчлүүлсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2019 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: /Т.Дамдинсүрэн/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

-----000-----

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн
2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
№03 тоот Тогтоолын хавсралт №4

**"Сүү" ХК-ийн "ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ"-Д САНАЛ АВАХ ХУУДАС**
/Хэлэлцэх асуудал №2-1/

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, "Холцдэй Инн" зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр

Регистрийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Кумулятив санал хураах аргаар өгөх саналын тоо:

№	"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Д.Ганбаатар	
2.	Д.Цэрэнжигмэд	
3.	Д.Жамьян	
4.	Б.Түвшинтөгс	
5.	Д.Уянгалянхуа	
6.	Ц.Соёл-Эрдэнэ	
7.	Д.Тунгалаг	
8.	С.Сүхболд	

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Та саналаа үзэг, зовоол бэлгээр тэмдэглэнэ үү. /Харандавгаар тэмдэглэсэн бол хүчингүйд тооцно/
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. ТУЗ-ийн гишүүдийн сонгох санал өгөхдөө кумулятив аргаар нэр дэвшигчид өгөх саналын тоо нь хэд ч байж болно. Харин нийлбэр дүн нь кумулятив аргаар өгөх саналын нийт тооноос хэтэрч болохгүй. Хатарсан тохиолдолд саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотариатаар гарчлүүлсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2019 оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: /Т.Дамдинсүрэн/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

-----000-----

“Сүү” ХК-ийн “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС
/Хэлэлцэх асуудал №2-2/

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холдэй Инн” зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр:

Регистрийн дугаар:
Эзэмшигч буй хувьцааны төрөл: Энгийн;

Эзэмшигч буй хувьцааны тоо:
Кумулятив санал хураах аргаар өгөх саналын тоо:

№	“Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Н.Цэрэндорж	
2.	Ш.Даваалымбэ	
3.	Г.Баяр	
4.	П.Мэндсайхан	

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Та саналаа уяаг, освал бэлдэр тэмдэглэнэ үү. /Харандагвар тэмдэглэсэн бол хүчингүйд тооцно/
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдсон.
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө кумулятив аргаар нэр дэвшигчдэд өгөх саналын тоо нь нэгд ч байж болно. Харин нийлбэр дүн нь кумулятив аргаар өгөх саналын нийт тооноос хэтэрч болохгүй.
4. Хураан тооцогдсон саналын хуудас хүчингүйд тооцогдсон.
5. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчлуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2019 оны сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: /Т.Дамдинсүрэн/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

—ооо—

“Сүү” ХК-ийн “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС
/Хэлэлцэх асуудал №3/

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холдэй Инн” зочид буудлын байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр:

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Эзэмшигч буй хувьцааны төрөл: Энгийн;

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	Компанийн дүрмэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал		

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Та санал авах хуудсыг бэлтгэхдөө өөрийн сонгож буй нэсэгт “/” освал + тэмдэглэж хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, бэлтгэсэн тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдсон.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд эрхлэх чөлөөтэй тохиолдолд өөрийн хариуцаж, үнэт цааны компанийн /ЦК/ дээр очиж туршын материалтай тэмцэхэд, санал авах хуудсаар саналаа өгнө.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотархатаар гарчлуулсан байна.

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2019 оны сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: /Т.Дамдинсүрэн/

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

—ооо—

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Тооллогын комисс тогтоол танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэн: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор, саналын хуудсаар авсан саналуудыг нэгтгэж дүнг гаргалаа. Одоо “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар хэлэлцсэн асуудал тус бүр дээр гарсан саналын дүнг та бүхэнд танилцуулъя.

№	Хэлэлцсэн асуудлууд	Зөвшөөрсөн хувьцааны санал		Татгалзсан хувьцааны санал	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ	320,264,253	93.1%	-	-
2.	ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ	Ердийн гишүүнээр:			
		1. Д.Ганбаатар	320,381,762	12.5%	-
		2. Д.Цэрэнжигмэд	320,160,288	12.49%	
		3. Б.Түвшинтөгс	320,237,971	12.49%	
		4. Д.Жамъян	320,126,687	12.5%	
		5. Д.Уянгалянхуа	320,164,100	12.5%	
		6. Ц.Соёл-Эрдэнэ	320,512,441	12.51%	

		7. Д.Тунгалаг	320,160,507	12.49%		
		8. С.Сүхболд	320,221,083	12.5%		
		Хараат бус гишүүнээр:				
		1. Н.Цэрэндорж	320,213,963	24.99%	-	-
		2. Ш.Даваалимбэ	320,418,457	25.01%		
		3. Г.Баяр	320,225,881	24.99%		
		4. П.Мэндсайхан	320,165,515	24.99%		
		3.	КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	320,259,207	93.1%	14,906

Хэлэлцсэн асуудлуудаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал 17:10 цагт хаасныг мэдэгдэв.

Тусгай тэмдэглэл: Байхгүй.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

/Б.ЦЭРЭНДОРЖ/

Хянасан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА:

/Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ/

